

ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ СУУРЬ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Сун Ин Тэг
Магистр

БНСУ-ын CQI Consulting Company
КОИСА олон улсын байгууллага

cqi.itsong@gmail.com

С. Туяа
Доктор (Ph. D.), дэд профессор

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

s.tuya@must.edu.mn

Хураангуй: Их дээд сургуулийн томоохон зорилтын нэг хэсэг нь нийгмийн хөгжил, мэдлэгийг үйлдвэрлэгч, баялагийг бүтээгч, технологи, инновацийн бүтээгч чадвартай, чанартай мэргэжилтэнг бэлтгэн нийгэмд нийлүүлж, шилдэг сургууль болох билээ. Аль ч их дээд сургуулийн хувьд бэлтгэн гаргаж буй мэргэжилтэн нь тухайн нийгмийн хэрэгцээ, ажил олгогчдод эрэлттэй нийцсэн байх нь үйл ажиллагааны том үнэлгээ, бахархал юм. Энэхүү өгүүлэлд манай орны дээд боловсролын тогтолцооны өнөөгийн байдал, аж үйлдвэрийн салбарын ажил эрхлэлт, “их дээд сургуулийн оюутны суурь чадварын оношлогоо”-гоор дамжуулан ажил хайгч, ажил олгогч, хариуцагч бүгд хамтдаа хэрхэн урагшлах, “оюутны суурь чадварыг хэмжих” нь дээд сургуулийн өрсөлдөх чадварыг хурдасгах, өөрчлөх сэдлийг өгч чадах, доороос эхлэн хийх (Bottom-up) стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж зэрэг асуудлыг хөндөн судаллаа.

Түлхүүр үгс: Их сургуулийн өрсөлдөх чадвар, оюутны суурь чадвар, үнэлгээ

УДИРТГАЛ

Их, дээд сургууль бүр өөрийн алсын хараа зорилго, стратегиа тодорхойлсон байдаг. Монголын томоохон сургууль болох МУИС-ийн алсын хараа нь “Дэлхийн түвшний их сургууль болох, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болох” бол, ШУТИС- нь “Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээх”, “Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох

хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацийг бүтээх” алсын хараа, эрхэм зорилготой. МУБИС-ийн тухайд “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, мэргэжилтэн бэлтгэх, сурах арга барилтай, хүнлэг, ёс зүйтэй оюутан” бэлтгэн гаргах хэтийн чиг хандлагатай байгааг харж болно. Энэхүү алсын хараа, зорилгодоо хүрэхийн тулд бид ямар асуудалд анхаарах вэ?

Технологийн эрин үед шаардлагатай байгаа хүний нөөц, мэргэжилтнүүдийг дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйцээр бэлтгэн гаргахад хэрхэн ажиллах вэ?, Монголын дээд боловсролын тогтолцоо хурдацтай өргөжин тэлж байгаа энэ цаг үед аж үйлдвэрийн салбар, ажил мэргэжлийн эрэлт хэрэгцээний байдалтай хэрхэн уялдаж байгаа вэ? зэрэг олон асуулт дээд боловсролын салбарт оршоор байна.

Их, дээд сургуульд суралцагчдын суурь чадварыг жил бүр үнэлж, дутагдаж байгаа чадварыг хэрхэн хөгжүүлэхэд их сургууль анхаарч, сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт оруулж байх нь нийгмийн хөгжилд хэрэгцээтэй мэргэжилтэнг бэлтгэн гаргах зорилгодоо хүрэх боломжийг бий болгох нэг арга зам гэж үзэж байгаа юм. Өндөр хөгжилтэй улс орнуудад суралцагчдын суурь чадварыг хөгжүүлэхэд их анхаарч, үнэлгээ хийн шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, сургалтыг цаг алдалгүй өөрчлөлтөөр хэрэгжүүлж ирсэн нь улс орны хөгжилд маш үнэтэй хувь нэмэр болж байгааг тэдний хөгжлийн түвшингээс харж болно.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Монгол улсад ч хамааралтай Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын давалгаа түрэн орж ирж байгаа бөгөөд интернэт ашиглах байдал илт ихсэж ард иргэдийн ихэнх нь интернэт орчинд орж, смарт утас

хэрэглэн Facebook болон SNS-д маш их их цагийг өнгөрүүлж байна. Тодорхой хүрээнд эдийн засагт суурилсан ашиг, үр дүнг чухалчилж байсан өнгөрсөн үеийн томоохон аж үйлдвэрийн тогтолцооноос супер холболт (super-connectivity) болон супер оюун ухааны (super-intelligence) онцлог чадвараар явагдах аж үйлдвэрийн 4-р хувьсгалын эрин үе рүү шилжиж байна [1]. Энэ цаг үеийг хурдтай хөгжиж буй техник технологийн хөгжилд суурилан хэрэглэгч бүрт тохирсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлэх массын захиалгат үйлдвэрлэл (mass customized production) хэмээн тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн үетэй адил их хэмжээний хөрөнгийг зарцуулан том үйлдвэр барьж, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулж, нэгж бүрийн үйлдвэрлэлийн зардлыг ариглан хэмнэдэг эдийн засгаас эрэлт бүхий газарт тохирсон үйлдвэрлэл явуулж бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой болсон.

Өмнөх үеийн эдийн засгийн тогтолцооноос ялгаатай техник технологийг нээж, түгээн дэлгэрүүлж чадах боловсон хүчнийг чухалчилахыг онцолсон байдаг. Герман, Япон, Солонгос гэх мэт үйлдвэрлэгч их гүрнүүдээс ялгаатай, дотоод зах зээл хязгаарлагдмал, тодорхой хүрээнд эдийн засгийг хөгжүүлэхэд амаргүй байгаа Монгол улсын хувьд эсрэгээрээ зах зээлийнхээ

хэмжээндээ тохирсон үйлдвэрлэл явуулах боломжтой учраас Аж үйлдвэрийн 4-р хувьсгал таатай боломж ч байж болно.

БНСУ-ын Засгийн газар холбогдох салбаруудаас санхүүжилт бүрдүүлэн програм хангамжийн дээд сургууль, хиймэл оюун ухааны мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх дээд сургуулийг хөгжүүлж, салбарын хүний нөөцийн хөгжилд шаардлагатай санхүүгээр хангаж байгаа бөгөөд бага, дунд, ахлах сургуульд кодчилох (Coding) сургалт ч хийгдэж байгаа [2]. Мөн банк, эмнэлэг ялангуяа сургуульд хүртэл хиймэл оюун ухааны ашиглалт өсөн нэмэгдэж байна. Улс орон бүр өрсөлдөх чадвартай техник технологийн хөгжил, боловсон хүчнийг бэлтгэх өрсөлдөөн өрнөж байгаа өнөө цаг үед дээд боловсролоор дамжуулан нийгэмд хөл тавьж буй боловсон хүчний талаарх ойлголтыг шинэчлэх нь илүү чухал. Улс үндэстний ирээдүйг авч явах мэргэжилтнийг бэлтгэхийн төлөөх хичээл зүтгэлд Засгийн газар болон дээд сургууль, аж ахуй нэгж хамтран оролцох шаардлагатай цаг үе ирээд байна [3].

Улс орны өрсөлдөх чадвараас дээд сургуулийн өрсөлдөх чадвар илүү чухал. Ялангуяа дээд боловсролыг дүүргээд нийгэмд гаран улс орныхоо өрсөлдөх чадварт хувь нэмэр оруулах төгсөгч мэргэжилтний чадавхи нь

өрсөлдөөний үндэс цөм юм. Төгсөгчдийн чадавхи нь их сургуулийн сургалт, судалгааны чадавхаас хамаардаг тул улс орнууд боловсролын байгууллагын сургалт, судалгааны ажлын чадамжийг сайжруулахад санхүүгээр хангах, төрөл бүрийн дэмжлэгээр өрсөлдөөнийг бий болгож байна. Энэхүү дэмжлэг, зүтгэлийг үр дүнтэй болгохын тулд дээд сургууль, Засгийн газар болон боловсролын үйлчилгээг авч буй суралцагчдын хувьд (аж ахуйн нэгж, эцэг эх) өрсөлдөх чадварыг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээг нэгэн зэрэг мэдэрч өөрчлөлт шинэчлэлтийг урагшлуулах дэмжлэгийг хамгийн их өгч чадна.

Монгол улс социализмыг дамжин ирсэн соёлоороо одоо ч Top-down байгаа бөгөөд үүнтэйгээ санал нэгдэн, ажил үүрэгтээ дассан байдалтай байна. Өөрчлөлт шинэчлэлтийг Top-down байдлаар явуулах юм бол уг үндэс, соёл, чанар өөрчлөгдөхгүй бөгөөд бүтэц систем гэх мэт гадна үзэмж төдий зүйл л өөрчлөгдөж анх тавьсан зорилгын биелэлтэнд алдаа гарсаар л байх болно.

Нөгөө талаас, доороос дээш чиглэсэн шинэтгэл нь сургалт, судалгаанд суурилан нэг шугамнаас өөрчлөлт шинэчлэлтийн хэрэгцээнд тулгуурлан эхлэж байгаа одоо цагт ажиллах соёл, нөхцөл байдлаа сайжруулах найдлагатай хэдий ч нэгдмэл хүч бий болгох хүртэл маш их цаг хугацаа, тэвчээр шаардагдах талтай, тэр нь гарцаагүй тодорхой

бүлгийнхний үзэл санааны шинэчлэлд түшиглэх бөгөөд үндсэн чиг зорилгоосоо хазайх гэх мэт сул талыг бий болгоно.

Хүрээлэн буй орчин маш хуртай өөрчлөгдөж байгаа учраас өөрчлөлтөнд тохирсон хариу арга хэмжээг зөвхөн бид хэрэгжүүлж, боломжийг тасралтгүй түгээж чадна гэдгийг ойлгох хэрэгтэй. Дээд сургуулийн сургалтын зорилго, агуулга нь зайлшгүй бөгөөд үүнд арга зүйн амин чухал өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд хэзээ бэлэн болохыг хүлээх боломжгүй юм. Харин “Их, дээд сургуулийн оюутны суурь чадварын оношлогоо”-гоор дамжуулан ажил хайгч, ажил олгогч, хариуцагч бүгд арга замаа хамтдаа урагшлуулах шаардлагтай. “Оюутны суурь чадварыг хэмжих” нь дээд сургуулийн өрсөлдөх чадварыг хурдасгах, өөрчлөх сэдлийг өгч чадах, доороос эхлэн хийх (Bottom-up) стратеги төлөвлөгөө юм.

Оюутны суурь чадварыг хэмжих нь мэдээж тухайн оюутан ирээдүйд ажиллах боломжтой байгууллагаа тодорхойлох, 4 жилийн туршид эзэмшсэн боловсролоо үнэлэх нь тухайн мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш нарт маш том нөлөө үзүүлнэ. Их, дээд сургуулийг сургалт, судалгаа гэх мэт чиг үүрэгт нь тулгуурлан өрсөлдөх чадварыг шалгах боломжтой байдаг учраас өрсөлдөөнийг дэмждэг төрийн бодлогод дээд сургуулийн хариу үйлдэл, гарч буй өөрчлөлт, мөн

шинэ амжилт болон эргэх холбоог хэмжих хэмжилтийг (loop) бий болгох нь Top-down байдалд унасан нөхцөл байдлыг хурдан шинэчлэх арга зам ч байж болно. Ямартай ч Top-down нөхцөл байдлаас гарахын тулд Засгийн газар, их, дээд сургууль онцгойлон хангалттай бэлтгэл хийх хэрэгтэй, ялангуяа Засгийн газраас дээд сургуулийн өөрчлөлтийг дэмжих их хэмжээний урамшуулал, санхүүжилтыг бий болгох шаардлагатай байгаа.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Монгол улсын дээд боловсролын тогтолцооны өнөөгийн байдал

Монгол улсын дээд боловсролын тогтолцооны өнөөгийн байдал маш хурдацтай өргөжин тэлсээр байгааг бид харж байна. Гэвч 2005-2006 оны хичээлийн жилд хамгийн ихдээ 180-д хүрч байсан дээд боловсролын байгууллагын тоо 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар 96-д хүрч 50 хувиар буурсан. Үүнээс төрийн өмчийн, төрийн өмчийн бус гэдгээс үл хамааран бүрэлдэхүүн сургууль, коллежийн түвшний боловсролын байгууллага эрс багассан бөгөөд үүнд төрийн өмчит сургуулийн хувьд 2005-2006 оны хичээлийн жилд 41-д хүрч байсан нь 2017-2018 онд 4 сургууль л үлдсэн бол төрийн өмчийн бус сургуулийн хувьд 2000-2001 оны хичээлийн жилд 131-д хүрч, 2017-2018 оны байдлаар 54 болж буурчээ. Дээрхтэй харьцуулбал их,

дээд сургуулийн эзлэх хувийн жин нь жил бүр өссөн байдалтай бөгөөд төрийн өмчийн их, дээд сургууль 1995-1996 оны байдлаар 6 байсан нь 2017-2018 оны хичээлийн жилд 14, төрийн өмчийн бус их, дээд сургууль нь 2000-2001 онд 3-аас 2017-2018 онд 21-д хүрсэн үзүүлэлтээс харж болно[4].

Боловсролын үйлчилгээг хүртэгчдийн хувьд их, дээд сургуулийг чухалчлах хандлага их байгаагаас коллежийн тоо буурсан ба Засгийн газрын зүгээс их, дээд сургуулийн боловсролын чиг хандлагыг илүү идэвхитэй дэмжсэн байдал ч ажиглагдаж байна.

Суралцаж буй оюутны хувьд 2017-2018 оны хичээлийн жилд оюутны тоо 156.600 хүрсэн нь 2010-2011 оны хичээлийн жилд хамгийн ихдээ 170.800 оюутан сурч байсан үеийнхтэй харьцуулвал 14.200-аар буурчээ. Оюутны тоо нь сургуулийн тоон өөрчлөлттэй уялдаа холбоотой байгааг бүрэлдэхүүн сургууль, коллежийн оюутны эзлэх хувь огцом буурсан мөн их, дээд сургуульд сурч буй оюутны хувийн жин огцом өссөн тоо баримтаас харж болно.

2017-2018 оны хичээлийн жилд нийт их, дээд сургуулийн оюутны тоо нь 87.900 хүрч суралцаж буй оюутны 56.1%-ийг эзлэж байгаа бөгөөд төрийн өмчийн бус их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан 31.2%-ийг эзлэж байна. Дээрх хоёр хэв шинжийн их, дээд сургуульд суралцаж буй

оюутны эзлэх хувийн жин нь 87.3%-тай байна.

Төрийн өмчийн бус их, дээд сургуулийн оюутны эзлэх хувь нь сүүлийн жилүүдэд огцом өсөж байгаа нь ч Монголын дээд боловсролын тогтолцооны онцлогтой холбоотой бөгөөд оюутны тоо хамгийн их байсан 2010-2011 онд нийт оюутны тоо 9.4% нь төрийн өмчийн бус их, дээд сургуульд, 16.4% төрийн өмчийн их, дээд сургуульд ногдож байсан байна. Харин 2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн бус их дээд сургуулийн оюутны тоо 31.2%-ийг эзэлж байгаа бол, төрийн өмчийн сургуульд 55,5% байна. Энэхүү өөрчлөлтөөс харвал шилжилтийн ихэнх хэсэг нь төрийн өмчийн бус дээд сургуульд шингэсэн байх магадлалтай.

Монголын дээд боловсролын байгууллагад элсэгчийн тоо хэмжээ тогтмол нэмэгдэж байгаа нь хугацааны хувьд харилцан адилгүй ч төгсөгчийн тоон өсөлтийн харвал 2000-2001 оны хичээлийн жилд 11,047 байсан төгсөгчдийн тоо 2016-2017 онд 34,681-д хүрсэн байна. 2000-2001 оноос 2016-2017 оны хичээлийн жилийн хугацаанд хамгийн өндөр хувьтай байсан мэргэжил болох барилгын инженерээр 23 хүн төгссөнөөс 1,772 болж 77 дахин, үйлчилгээний мэргэжлээр төгсөгчид 158 байснаас 1,735 болж 11 дахин нэмэгджээ. Төгсөгчдийн тоо бизнесийн мэргэжлээр хамгийн

огцом өссөн байх бөгөөд 2000-2001 оны хичээлийн жилд 1,648 төгсөгчөөс 2016-2017 оны хичээлийн жилд 7,004-аар нэмэгдэж 8,652 хүн төгсчээ. Мөн хугацаанд анагаахын мэргэжлээр 704 төгсөгчөөс 4,365 болж огцом өссөн, инженерийн чиглэлд 1,352 хүн төгсөж байснаас 4,302 болж даруй 3,2 дахин нэмэгдсэн байна[5]. Оюутны элсэлт болон төгсөлт нь аж үйлдвэрийн салбарт хүний нөөцийн эрэлт хэрэгцээтэй хамааралтай хэмээн үзвэл энэ хугацаанд бизнесийн удирдлага, эмч, инженер, багшийн мэргэжил их хэмжээгээр тогтмол нэмэгдэж иржээ хэмээн таамаглаж байна.

Хүснэгт 1 [Дээд боловсрол эзэмшигчдийн тоо]

Сургалтын байгууллагын ангилал	2000/2001	2005/2006	2010/2011	2015/2016	2016/2017	
					Хүн	%
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	2,533	2,893	5,775	5,508	5,193	15.0
Хүмүүнлэгийн ухаан	1,065	1,895	2,565	1,476	1,303	3.8
Урлагийн төрөл, урлаг судлал	279	465	609	674	705	2.0
Хууль эрх зүй	749	1,676	2,280	2,111	1,771	5.1
Нийгмийн шинжлэл	552	2,190	3,396	1,916	1,758	5.1
Худалдаа, бизнесийн удирдлага	1,648	5,960	8,383	9,227	8,652	24.9
Нийтийн мэдээлэл, сэтгүүл зүй	185	384	485	494	502	1.4
Математик, компьютер	242	616	1,212	871	850	2.5
Үйлчилгээ	158	1,267	2,124	1,860	1,735	5.0
Байгалийн шинжлэл	347	720	914	866	550	1.6
Анагаах ухаан	704	1,791	3,135	3,827	4,365	12.6
Инженер	1,353	1,435	3,543	4,509	4,302	12.4
Бүгд	11,047	23,628	35,847	35,889	34,681	100.0

Эх сурвалж: УСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ, 2017

Монголын аж үйлдвэрлэл, ажил эрхлэлтийн байдал, алсын хараа

Монгол улсын онцлог нь өргөн уудам нутаг дэвсгэртэй (1564 км 2100 км2 бөгөөд Солонгос улсаас 16 дахин том), бага хүн амтай, (2019 оны 4 сарын 8-ны байдлаар нийт хүн амын тоо 3.238.479) байгалийн баялаг хангалттай (нүүрс, төмөр, зэс, цайр гэх мэт), урт, хатуу хахир өвлийн улиралтай. Гэвч нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ өндөр байх нөхцөл нь бүрдсэн ч гэсэн хүн амын тоо нь дотоодын зах зээлийг бүрдүүлж чадахуйц хэмжээний биш учраас байгалийн баялагийг нээж, боловсруулах нэмүү өртгийг шингээсэн аж үйлдвэрийн салбар сул, ихэндээ гадаадын аж үйлдвэрийг түшиглэн нөөц баялагийн хайгуул, илрүүлэлт хийж, түүхийгээр нь экспортоор гаргасны дараа бэлэн болсон бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэх байдлаар эдийн засгаа бүтэцжүүлж байна. Ийнхүү эдийн засгийн онцлог бүхий ДНБ-ын эзлэх хувь уул уурхайн салбарт тогтмол байдлаар хамгийн өндөр байгаа бөгөөд газар тариалан, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашин засварын ажил удаалж байгааг статистикийн мэдээллээс харж болно. Тухайлбал 2010 оноос хойш санхүү даатгалын салбарын ДНБ-д эзлэх хувь маш ихээр өсөн нэмэгдсэн бөгөөд 2010 онд 2,5%-иас 2017 онд 4,2% болон ДНБ дэх нийт эзлэх хувь нь 6,6%-

иар нэмэгдэж, газар тариалан 11,7%-13,4% буюу 1,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нөгөө талаасаа үйлдвэрлэл 6,8%-6,6% руу, нийтийн удирдлага, батлан хамгаалах салбарын эзлэх хувь ч мөн 4,4%-2,7%-иар тус тус буурчээ.

Хүснэгт 2 [ДНБ-ний хэмжээг эдийн засгийн салбараар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр]

Салбар	2010		2017		C= B-A
	төгрөг	%(A)	төгрөг	%(B)	
Бүгд	9,756,588.4	100.0	16,849,497.9	100.0	0.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, агнуур	1,144,697.9	11.7	2,252,190.3	13.4	1.6
Уул уурхайн олборлолт	2,102,157.9	21.5	3,692,752.9	21.9	0.4
Боловсруулах үйлдвэрлэл	664,815.3	6.8	1,107,718.1	6.6	-0.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	190,211.6	1.9	265,154.4	1.6	-0.4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31,210.6	0.3	31,102.1	0.2	-0.1
Барилга утсралт	250,230.7	2.6	545,666.0	3.2	0.7
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашин, мотоцикл, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	1,199,007.2	12.3	2,160,298.9	12.8	0.5
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	677,906.2	6.9	1,281,991.6	7.6	0.7
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	52,631.0	0.5	79,526.6	0.5	-0.1
Мэдээлэл харилцаа холбооны	255,691.2	2.6	394,588.6	2.3	-0.3
Санхүүгийн гүйлгээ даатгалын үйлчилгээ	239,607.2	2.5	1,118,043.6	6.6	4.2

Эх сурвалж: УСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ, 2017

Ажилгүйдлийн хувь 1995 онд 5,5%, 2000 онд 4,6%-иар тогтмол буурч байсан ч 2005 онд бүрэн ажил эрхлэлт 3,3%-д хүрч, хурдтай буурсаар 2017 оны байдлаар 8,8%-д хүрсэн юм.

Орон нутгийн ажилгүйдлийн түвшин улсын дундажтай харьцуулбал өндөр хувийг эзлэх хандлагатай байгаа бөгөөд хотын иргэдийн ажилгүйдэл 1995 оноос 2017 он хүртэл улсын нийт ажилгүйдлийн дундажтай харьцуулбал өндөр байсан удаа нэг ч байхгүй байна. Улаанбаатар хотын иргэдийн хүн ам болон эдийн засгийн эзлэх хувь нь асар их учраас ажилгүйдэл бага байгаа ч энэ тоон хэмжээ нь орон нутагт хурцадмал, хөдөөгөөс хот руу хүн ам нь төвлөрч байгаа нь ажилгүйдлын асуудлыг шийдвэрлэх шалтгаан ч байж болно. Мэдээ материалуудаас харахад хүн ам Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл тасрахгүй байгаа бөгөөд 2017 оноос өнөөг хүртэл 46% буюу 1.463.000 иргэн хотод амьдарч байна.

2010 оноос тогтмол байдлаар Монгол улсын ДНБ нь өнөөг хүртэл 1,7 дахин тогтмол өссөн. 2010 оноос хойш тасралтгүй өссөн ажилгүйдлыг хувийг бууруулж чадахгүй байгаа энэ үед дээд боловсролын хүрээ хурдтай тэлж, 2010 оноос хойш жил бүр 35.000 хүн гадаад дотоодод сургууль төгсөж байна. Ажил

эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг харвал нийт салбарын ажилчдын тоо 2010 онд 10337 байснаа 2017 онд 12.383 болж даруй 19% -иар өссөн байна. ҮНБ-ний эзлэх хувиас гадна ажил эрхлэлтийн байдлаар газар тариалангийн салбар хамгийн өндөр хувьтай байсаар ирсэн. 2010 онд 33,5% -иас 5%-иар буурсан хэдий ч 2017 оноос өнөөг хүртэлх байдлаар энэ салбар 28,8%-иар хүн амын ажил эрхлэлтийг хамгийн их хангаж байна. Түүнчлэн газар тариалангийн салбарын дараа бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин засварын ажил 16,5%, боловсролын салбарт 8%, үйлдвэрийн ажил 7,5%, төрийн алба болон батлан хамгаалах 6,6%, тээвэр болон жижиг худалдаа эрхлэгч 5,9%, барилгын ажил 5,7%-иар тус тус ажил эрхлэлттэй байна. Эндээс харвал үйлдвэрийн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн хувь 2000 онд 6,7% түвшингээс аажим аажмаар өсөх хандлага ажиглагдаж байгаа ч 2017 онд 7,5%-иас хэтрээгүй, ҮНБ-нд эзлэх хувийн жин нь 21,9%-д хүрч байгаа уул уурхайн салбарын ажил эрхлэлтийн түвшин 4,2%-иас ч хэтрэхгүй байна.

Өмнө дурьдсанчлан 2017 оны нийт аж үйлдвэрлэлд хөдөлмөр эрхлэгчдийн тоог 2010 онтой харьцуулбал 204.700-аар өссөн, мөн хугацаанд жил бүр 35.000 хүн дотоод, гадаадын их дээд сургууль төгсөж нийгэмд хөл тавьсан гэж үзвэл дээд боловсрол эзэмшсэн

төгсөгчид 280.000-д хүрсэн байна, ажил эрхлэгчдийн өссөн тоог их, дээд сургууль төгсөгчид эзэлсэн гэж үзвэл ойролцоогоор 80.000 гаруй ажлын байрны хомсдол үүсэж байна.

Хүснэгт 3 [Ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны ангилалаар] (мянган хүн,%)

Салбар	2010		2017		C=B-A	C/A Ч100
	ХҮН (А)	%	ХҮН (В)	%		
Бүгд	1,033.7	100.0	1,238.3	100.0	204.6	19.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуур	346.6	33.5	356.4	28.8	9.8	2.8
Уул уурхайн олборлолт	34.1	3.3	52.0	4.2	17.9	52.5
Боловсруулах үйлдвэрлэл	64.8	6.3	93.1	7.5	28.3	43.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12.4	1.2	17.5	1.4	5.1	41.1
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	7.8	0.8	4.9	0.4	-2.9	-37.2
Барилга угсралт	48.8	4.7	70.6	5.7	21.8	44.7
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашин, мотоцикл, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	146.2	14.1	204.5	16.5	58.3	39.9
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	76.5	7.4	72.7	5.9	-3.8	-5.0
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	27.7	2.7	36.4	2.9	8.7	31.4
Мэдээлэл харилцаа холбооны	14.5	1.4	14.5	1.2	0.0	0.0
Санхүүгийн гүйлгээ даатгалын үйлчилгээ	15.2	1.5	24.1	1.9	8.9	58.6

Эх сурвалж: УЦХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл. ҮБ. 2017

Байгалийн нөөц хязгааргүй зүйл биш юм, бага хүн амтай ч ард түмэн нь өндөр ашиг орлоготойгоороо бахархдаг хөгжингүй улсуудтай Монгол улсыг харьцуулвал гадаад худалдаа, эдийн засгийн тогтолцоо удаашралтай байгаагаас шалтгаалж улс орны нөөц, дотоодын зах зээлийн хүрээ бага, хатуу ширүүн урт өвлийг даван туулахын тулд бэлтгэл ажил их хийх хэрэгтэй зэрэг тус улсад шинээр бүтээн байгуулах ажлыг урагшлуулах хүний нөөц хамгийн чухал байна.

Их сургуулийн эдийн засгийн өрсөлдөх чадвартай холбоотой БНСУ-ын жишээ

БНСУ 1945 онд Японы дарангуйллаас чөлөөлөгдөж, 1950 оноос хойш 3 жилийн турш үргэлжилсэн иргэний дайны эмгэнэлт балгасан дундаас өнөөдрийн 2019 оны хөгжлийн түвшинд хүрсэн юм. 1960-1980-аад оны үед Засгийн газар аж үйлдвэржилтийн бодлогод тулгуурлан үйлдвэрлэлийг дэмжихэд анхаарлаа хандуулж, энэ салбарт олон тооны өндөр ур чадвар бүхий ажлын байрыг бий болгож, салбарын хөгжлийг дэмжих зорилгоор дээд боловсролын цар хүрээгээ тасралтгүй өргөжүүлж байв[6]. 1990-ээд онд олон улсын хамтын нийгэм, хил хязгааргүй өрсөлдөөний эрин зуунд шилжиж, үйлдвэрийн салбарын өсөлтгүй "ажил эрхлэлтгүй дэвшил" буюу "Мэдлэгийн нийгэм"(Knowledge Society) гэж нэрлэгдэх болсон.

Өмнөх үеэс ч илүү технологи, мэдлэгийг эзэмшсэн хүн чухал болж байгаа энэ цаг үетэй зэрэгцэн улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг бий болгох цөм элемент болох "мэргэжилтэн"-г бэлтгэх нь чухалчилагдаж, Засгийн газрын болоод нийгмийн анхаарал нь боловсон хүчнийг бэлтгэж байгаа их сургуулийн сургалтанд төвлөрч байна. Ялангуяа их сургуулийн зорилго нь боловсон хүчнийг нийгэмд бэлтгэн гаргадаг сүүлийн шатны байгууллагын хувьд дээд боловсролын өрсөлдөх чадвар улсын орны өрсөлдөх чадвартай шууд холбоотой байх ойлголтыг нэмэгдүүлэхэд оршино.

Засгийн газар төсвийг батлан их сургуульд дэмжлэг үзүүлж, үүнийхээ хариуд нийгэмд шаардлагатай байгаа сургалт, судалгаагаар дамжуулан олон улсад өрсөлдөх чадвартай боловсон хүчнийг бэлтгэхэд эрмэлзэж, үүнийгээ шалгадаг олон төрлийн үнэлгээг хэрэгжүүлснээр, бодит мэдээллийг компани аж ахуйн нэгж, элсэлтийн шалгалтанд бэлтгэж буй оюутан, эцэг эхэд нээлттэйгээр хүргэж хүссэн мэргэжил, дээд сургууль болон танхимаа сонгон суралцах боломжийг бий болгож өгөх хэрэгтэй болсон.

Их, дээд сургуулийн өрсөлдөөн нь зөвхөн дотооддоо биш даяаршилтыг дагаж өөрийн сургуулийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхийг хүсэж байгаа байдлаа тусган өрсөлдөх чадвараа

нэмэгдүүлэх арга замыг бий болгоход орших бөгөөд Монголын томоохон их дээд сургуулийн хувьд ч Азийн шилдэг 100 сургуульд багтах алсын хараа зорилттой байгаагаас харж болно. Одоогийн байдлаар БНСУ-ын их, дээд сургуулийг үнэлэх ажил хэтэрхий их байгаа нь сургуульд ачаа дарамт өгч байгаа боловч үнэлгээгээрээ дамжуулан тэдний өрсөлдөх чадварыг тасралтгүй сайжруулж байгаа учраас хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалтай байгаа юм. Их Британийн “The Times” сониноос хэрэгжүүлсэн дэлхийн их, дээд сургуулийн рангийн THE, QS үнэлгээ, БНСУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан их сургуулийн үнэлгээ, эрдэм шинжилгээний салбарын үнэлгээ нь үүнд ихээхэн дэмжлэг үзүүлдэг. Баримтаас харвал, THE үнэлгээг (World University Rankings) дагаад 2011-2012 оны дэлхийн их сургуулийн чансааны эхний 400 БНСУ-ын улсын долоон их сургууль жагссан бол 2019-2020 онд 9 болж нэмэгдсэн байна[7]. БНСУ-ын Засгийн газраас дээд боловсролын салбарт үзүүлэх хөрөнгө оруулалт, дэмжлэг сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн ч харамсаар нөхцөл байдал байсаар байна. Бусад орнууд ч их дээд сургуулийн ач холбогдлыг чухалчлан ойлгож, шинэчлэл, инновацийг нэвтрүүлэхийн хүлээн зөвшөөрч байгаа тул дэлхийн их, дээд сургуулийн зэрэглэлийг өөрчлөх амаргүй.

БНСУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй олон төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийн үнэлгээгээр дамжуулан их, дээд сургуулийн оролцоотойгоор хөгжиж байгаа бизнесийг үнэлдэг. Үүнд аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагаагаараа тэргүүлэх их дээд сургуулийн сургалтын үнэлгээ, шинэ бүтээн байгуулалт, манлайлагч сургуулийн үнэлгээ, программ хангамжын төв дээд сургуулийн үнэлгээ, хиймэл оюун ухааны дээд сургуулийн үнэлгээ гэх мэт олон төрлийн үнэлгээ багтдаг. Дээрх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн салбарт нь хүний нөөцийг бэлтгэн гаргахад тохирсон санхүүжилтыг Засгийн газраас дэмжин олгодог. Дээд сургууль дотроо ч үнэлгээг тасралтгүйгээр хэрэгжүүлж, эрдэм судлалын салбар бүрээр сургалт, судалгааны ажлын амжилтанд суурилсан санхүүгийн ялгаатай дэмжлэгийг үзүүлдэг, багшийн ажлын үнэлгээ ч үүнд багтдаг. Сургалтын үйл явц, хичээлийн сэдвийн тасралтгүй өөрчлөлтөөр дамжуулан хүрээлэн буй орчинтойгоо харилцах чадварыг бэхжүүлэхийн тулд төгсөгчид нь ажиллах үйлдвэр, салбарынхаа санаа бодлыг сонсох, үйлдвэрлэлийн мэргэжилтнээр багш нарыг ажиллуулах, оюутны өөрчлөлтийн явцыг тасралтгүй ажиглаж, анхаарч оюутан, багш, аж үйлдвэрийн хамтын ажиллагаагаар шилдэг боловсон хүчнийг бэлтгэхэд хүчээ нэгтгэж байгаа.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монголын дээд боловсролын талаарх ойлголт, шинэчлэлтэнд тулгарч буй саад бэрхшээл

Сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байгаа дээд боловсролын эрэлтийг төрийн өмчит сургуулиас илүү төрийн өмчит бус сургууль байгуулах замаар шингээж, хувийн өмчийг нэмэгдүүлэх хандлага ажиглагдсаар ирсэн. Их, дээд сургууль, суралцаж байгаа оюутны тоо хэмжээ гэх мэт томоохон их дээд сургуульд дээд боловсролын асуудлаа хариуцуулж, найдах байдлаар бодлогоо хэрэгжүүлж ирсэн гэж үзэж байна. Засгийн газар жижиг багахан хүрээтэй сургуулийн тасралтгүй үйл ажиллагааны чадамж, сургалтын чанарт эргэлзсэн учраас жил бүр жижиг сургуулийг цомхотгох, хаах зэргээр тоог бууруулах, нөгөө талаас томоохон, чадамжтай сургуулийг бий болгох тал дээр анхаарч байна (Боловсролын тогтолцооны өнөөгийн байдал хэсэгт дурьдсан статистик тоо баримтаас энэхүү дүгнэлтийг хийж болохоор байгаа юм). Өөрөөр хэлбэл төрийн өмчийн их дээд сургуулийг дэмжих төсөв нь барилгын урсгал засвар болон нийтийн зориулалтаар ашиглаж байгаа байрны зардлыг хангах хэмжээнд л байна. Эдгээр сургуульд ч гэсэн мөн адил багшийн цалин хөлсийг оюутны төлбөрөөс бүрдүүлж, санхүүгийн зохицуулалтыг хийж байгаа. Ийм

нөхцөл байдалд Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсролын, тэр дундаа их, дээд сургуульд шинэчлэлт хийх нь маш хэцүү байх болно. Залуучууд БНСУ-д сурч боловсрох хүсэл эрмэлзэл өндөр байгаа нь дээд сургуулийн хүрээнд бий болгосон амжилт үр дүнгээ хэрэглэгчиддээ бүрэн дүүрэн ойлгуулж таниулж чадахгүй байгаатай холбоотой байж ч болно, мөн хэрэглэгчийн болоод бизнесийн байгууллага, эцэг эхийн дуу хоолой дээд боловсролын байгууллагад хүчтэй нөлөөлж чадахгүй байгаа нь ч бодит үнэн байна.

Идэвхгүй хандлага болон Top-down шинжийн үзэлтэй соёлын үндэс суурь гүнзгий харагдах бөгөөд багш нэг бүрээр харвал үнэхээр академик эрх чөлөөтэй мэт харагдаж байгаа ч өөрчлөлт шинэчлэлтийн явцаас харахад академик эрх чөлөөтэй байдал байхгүй байна.

Төсвийн эрх нь сургуулийн удирдах хэсэгт бүгд төвлөрөх бөгөөд бүрэлдэхүүн сургууль нь төсөвт төлөвлөгдөөгүй тохиолдолд ямар нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй байна. Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд багийн гишүүдийн хооронд үүссэн хэрэгцээ шаардлагын талаар бүгд ижил төсөөлөлтэй байх албагүй ч шинэчлэлтийг урагшлуулах тал дээр оролцогч талуудын дэмжлэг-төсөв, системийг багтаасан, шинэчлэлтийг зөв явуулах чиг

хандлага гэх мэт зүйл шаардлагатай байна.

Үндэсний хэмжээний сурах хүсэл эрмэлзэлтэй харьцуулбал боловсрол, өрсөлдөх чадварын талаарх иргэдийн ойлголт дутмаг, үүнээс улбаалаад их, дээд сургуулийн сургалт, өрсөлдөх чадварыг сайжруулахын төлөөх шаардлагатай арга хэмжээг авч ажиллах өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх нэгдсэн ойлголт бүрэлдэн бий болоогүй байна.

Нэмж дурдахад, санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа үед инновацийн зардлыг дэмжих нь амаргүй юм.

БНСУ-дахь “оюутны суурь чадварын оношилгоо (K-CESA)”

K-CESA-ын зорилго нь оюутны мэргэжлийн суурь ур чадварыг хэмжсэнээр нийгмийн өөрчлөлт, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэхэд уриалах, өөрийн суурь чадвар ямар түвшинд байгааг оношилж, хөдөлмөр эрхлэх чадварыг сайжруулахад хувь хүний хөгжлийг чиглүүлэх, их, дээд сургууль хүний хөгжлийн суурь ур чадварын түвшинг тодорхойлохуйц удирдлагаар хангана[8]. Зорилгыг илүү нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Хувийн хөгжлийг бий болгоход чиглүүлэх: Оюутан суурь чадварыг оношилж, оношлогооны үр дүнд суурилан өөрийгөө хөгжүүлэхэд чиглүүлэх

- Сургалтын хөтөлбөр боловсруулж сайжруулах: Оношлогооны үр дүнд

дүн шинжилгээ хийж, дээд сургуулийн чадавхийг үнэлэх, түүндээ суурилсан сургалтын хөтөлбөр програмыг боловсруулах

- Мэргэжилтнийг хөгжүүлэн төлөвшүүлэх: Суурь чадамжид нь тулгуурлан хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг тусгаж, нийгмийн хөгжил, байгууллагад хэрэгтэй хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх орчинг бүрдүүлэх

A. K-CESA ТАНИЛЦУУЛГА

○ Оюутны суурь чадварын түвшинг тодорхойлж карьер хөгжилд нь дэмжлэг үзүүлээд зогсохгүй сургалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц зорилгоор БНСУ-ын Боловсролын яам (Ministry of Education of South Korea), БНСУ-ын мэргэжлийн боловсрол, сургалт, судалгааны хүрээлэнгээс (Korea Research Institute for Vocational Education and Training, KRIVET), Боловсролын Үнэлгээний Нийгэмлэг (Korean Society for Educational Evaluation) болон олон мэргэжилтний дэмжлэгтэйгээр оношлогооны хэрэглэгдэхүүнийг боловсруулсан. 2007 оноос оюутны суурь чадварыг оношлох зорилгоор БНСУ-ын мэргэжлийн боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс вэбд суурилан боловсруулсан бөгөөд 2008 он хүртэл 120 гаруй их дээд сургууль, 140.000 гаруй оюутныг хамруулсан байна[9].

○ Суурь чадвар (Essential Skills)-ыг 6 хүрээг хамруулан оношлодог.

● Суурь чадвар гэдэг нь ажил албан тушаалаас үл хамааран дийлэнх мэргэжлээр амжилттай ажиллахад шаардлагатай мэдлэг, дадал чадвар, хандлага юм.

● K-CESA-ын үнэлгээ нь мэргэжилтэн Delphi-ийн судалгаагаар их, дээд сургууль, үйлдвэрийн мэргэжилтнүүдийн чухал хэмээн үзсэн зургаан хэсгээс бүрдэнэ.

Хүснэгт 4 K-CESA-ийн бүтэц

Хүрээ	Бүрэлдэхүүн хэсэг	Асуулт	Асуултын хэлбэр	Цагийн хязгаар
Харилцааны чадвар	Сонсох Мэтгэлцэх, Зохицуулах Унших Бичих Ярих	10 10 10 1 1	Сонголт (сонсох) Сонголт (сонсох) сонголт гүйцэтгэх гүйцэтгэх	15мин 20мин 15мин 20мин 10мин
Ерөнхий чадвар	Уян хатан байдал түрэмгий байдал Олон үндэстний талаарх мэдлэг, ойлголт Даяаршил, эдийн засгийн талаарх ойлголт	38	Олон сонголт	30мин
Олон нийтгүй харилцах чадвар	Сэтгэл хөдлөл Хамтран ажиллах Зохицуулах Удирдах Бүтэц зохион байгуулалтын талаарх ойлголт	50	Өөрийн үнэлгээ (5 оноо хүртэл)	Цаг хязгааргүй
Нэгтгэн дүгнэх чадвар	Аналитик сэтгэлгээ Онцлог сэтгэлгээ Үнэлгээний сэтгэлгээ Альтернатив сэтгэлгээ	8	гүйцэтгэх	90мин
Дата мэдээлэл, техник ашиглах	Агуулгын хүрээ; дата бааз, мэдээлэл, техник Гүйцэтгэх зүйл; цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах	30	Олон сонголт	45мин

Өөрийгөө удирдах чадвар	Өөрийгөө удирдан суралцах чадвар Зорилгод чиглэсэн төлөвлөгөө зохион гүйцэтгэх чадвар Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар Мэргэжлийн ёс зүй	60	Өөрийн үнэлгээ (5оноо хүртэл)	Цаг хязгааргүй
-------------------------	---	----	-------------------------------	----------------

* Өөрийн үнэлгээ; Асуултын субъектив үнэлгээ

* Олон сонголт: Объектив асуулт

* Гүйцэтгэх хэлбэр: Материалыг уншаад (сонсоод) тохирсон хариултыг бичвэл(ярьвал) шалгагч хариултанд оноо өгнө.

БНСУ-д одоогийн байдлаар нэг оюутанд ноогдох суурь чадварын оношлогооны зардал 40.000 вон байна. Хувиасаа мөнгө гаргахад үнэтэй хэдий ч хэрэгцээгээ дагаад оношлогоо, үнэлгээг оюутан бүр хийлгэж байна. Өнөөг хүртэл сургалтын үйл явцийг хэмжихэд сургуулиуд дэмжин оролцсон бөгөөд оюутнууд маш их цаг, зүтгэл гарган оношлогооны шалгалт өгөх шаардлагатай болдог учир зардлыг сургуулиас хариуцдаг, түүнчлэн оролцогчдод зардалд тохирсон хэмжээний урамшуулал (бэлгийн гэрчилгээ гэх мэт)-ийг өгөх байдлаар дэмжлэг үзүүлнэ.

Их, дээд сургуулийн оюутны суурь чадварыг оношлох, үнэлэх замаар өөрчлөлтийг доороос нь эхлэх, сургалттай холбоотой бүх оролцогч талуудын ойлголтын шинэчлэлтийг эрчимжүүлэх боломжтой. Сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлтээр дамжуулан Монгол улс дээд боловсролын өрсөлдөх чадварыг сайжруулъя, үйлдвэрийн салбарын ажил эрхлэлтийг тэлье гэвэл оюутны суурь чадварын оношилгоогоор дамжуулан дунд болон урт

хугацаагаар чанарын өсөлтийг бий болгох үйл явцыг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

- ① Сургууль бүр төгсөгчдийн суурь чадварын оношлогоог хийх
- ② Оюутны суурь чадварын үнэлгээний үр дүнг ажилд авах байгууллагад танилцуулж байх (богино хугацаанд оношилгооны үр дүнг дурьдах ч байгууллага шинэ ажилтны суурь чадварт тулгуурлан ажилд авах чиг хандлагаар боловсруулагдана)
- ③ Байгууллага дунд хугацаандаа суурь чадварын оношлогооны үр дүн, ажилчдынхаа ажлын гүйцэтгэлд үндэслэн боловсон хүчнийхээ суурь чадварыг тодорхойлж, ажилд авах хандлагыг бүрдүүлнэ.
- ④ Их сургууль нь байгууллагын ажилтан авахад шаардагдах чиг хандлагыг сургалтын хөтөлбөртөө тусгах. Энэ хүрээнд хичээлийн сэдэв бүр нь суурь ур чадварын аль хэсэг нь хамааралтай байна, багшийн сургалтын арга зүйд тохирч байгаа эсэх, сургах арга барил зохистой эсэх талаар салбарынхан, мэргэжилтэн хамтран судалгааны ажлыг идэвхжүүлнэ.
- ⑤ Эцэст нь их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр суралцагчдынхаа чадварыг хэрхэн өөрчлөж байгааг шалгахын тулд шинээр элсэгчдээс эхлэн суурь

чадварыг оношлох шаардлага бий болж байна. Суурь чадварын оношлогооны системийг нэвтрүүлэхдээ элсэгч төгсөгчдийг аль алиныг суурь чадварын оношлогоонд хамруулахаар тодорхойлсон байдаг.

ДҮГНЭЛТ

Улс орны хөгжил, иргэдийн ажил эрхлэлт, үйлдвэрийн салбарын дэвшил нь боловсролын үйлчилгээ, бэлтгэн нийлүүлж буй мэргэжилтний чадвараас бүрэн шалтгаалах юм. Аж үйлдвэрийн эрин үед их сургуулиудын чансааг үнэлэн эрэмбэлж өрсөлдөөнийг бий болгож байна. Хүний нөөцөөр дутагдалтай байгаа олон салбар, ажилгүйдлийн нөхцөл байдлыг бууруулахад бэлтгэн гаргаж буй оюутны чадвар маш чухал гэдэг нь тодорхой билээ. Ялангуяа дээд боловсролыг дүүргээд нийгэмд гаран улс орныхоо өрсөлдөх чадварт хувь нэмэр оруулах төгсөгч мэргэжилтний чадавхи нь өрсөлдөөний үндэс цөм юм.

Боловсролын үйлчилгээг авч буй суралцагчдын хувьд (аж ахуйн нэгж, эцэг эх) өрсөлдөх чадварыг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээг нэгэн зэрэг мэдэрч өөрчлөлт шинэчлэлтийг урагшлуулах дэмжлэгийг хамгийн их өгч чадах бөгөөд энэхүү үнэлгээний системийг их дээд сургууль тогтмол хэрэгжүүлж үйл ажиллагаандаа ашиглах нь чухал болсон байна.

НОМ ЗҮЙ

1. Kurtzweil, Ray 'The Singularity is near'6 2005. USA Amy Hill.
2. Service The US Commercial. 2017.
3. Song In Taeg. The higher education system of Korea (Understanding the structure and issues). One Asia Foundation. 2019.11.25.
4. NSO. Mongolian Statistical yearbook. 2017.
5. NSO. Mongolian Statistical yearbook. 2017.
6. Klaus Schwab, 제 4 차 산업혁명, 송경진 역, 2016, 새로운 현재
7. <http://www.timeshighereducation.com/world-university-rankings>
8. 안혜원, 대학생 핵심역량진단(K-CESA) 설명회, 2019, 부산대학교
9. <http://www.kcesa.re.kr/index.do>